

Япон хэлний “Хитонен” клубын товч тайлан



Япон хэлний “Хитонен” клуб нь оюутнуудын санаачлагаар 2017 оны 3-р сарын 14-ний өдөр байгуулагдсан. ШУТИС-ийн нийт оюутнуудыг хамарсан үйл ажиллагаа явуулдаг.

“Хитонен” клуб нь япон хэл, соёлыг түгээн дэлгэрүүлэх, сонирхогч оюутан залуус болон япон хэлний хичээл сонгон суралцаж байгаа оюутнуудыг дэмжиж идэвхжүүлэх, хичээлд нь туслах, илүү хялбараар хөгжих, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөхөд нь туслах зорилготой сайн дурын клуб юм.

2017-2022 онуудад клубын зөвлөх багшаар Б.Ундармаа, 2022-2023 оны хичээлийн жилээс зөвлөх багшаар япон хэлний багш Т.Солонго, клубын ахлагчаар “Техник технологийн орчуулга /Япон хэл/” мэргэжлийн 2-р курсын оюутан Т.Дөлгөөн, Мишээл нар ажиллаж байна.

Клубын үйл ажиллагааны чиглэл нь япон хэл, соёлын хичээл, японы уламжлалт болон орчин үеийн соёл урлаг, дуу хөгжим, анимэ танилцуулах, япон оюутнууд, Монголд амьдарч ажиллаж байгаа япон хүмүүстэй ярианы хичээл зохион байгуулах, япон хэлний түвшин тогтоох шалгалтад бэлтгэх зорилтот сургалт зохион байгуулах, Япон орон, хэл соёлтой холбоотой үйл ажиллагаа, арга хэмжээний танилцуулга мэдээлэл хийх, оюутан залуусыг хамруулах зэрэг болно.

2017-2019 онуудад клубын ахлагчаар БАС-ийн оюутан Э.Ганхүлэг ажиллаж, гишүүдийн тоо 15-95 хооронд байв. Үүнээс идэвхтэй гишүүд 15-25. Зохион байгуулсан үйл ажиллагаануудаас дурдвал Японд сурах болон Японы холбогдолтой соёлын өдөрлөг, мэдээллийн яармаг, ШУТИС-ийн клубудын нэгдсэн зөвлөлөөс зохион байгуулдаг арга хэмжээнүүд юм.

2019-2020 оны хичээлийн жилээс ГХС-ийн япон хэлний ангийн оюутнууд клубын ахлагчаар ажиллах болсон ба уламжлалт арга хэмжээнүүд болон япон хэл, соёл танилцуулах хичээл сургалт, мэргэжилтэн багшийн хамт ярианы цаг зэрэг хамтран хөгжих цагийг нэмж өгсөн.

2022-2023 оны хичээлийн жилээс ярианы цагийг Монголд суралцаж буй япон оюутнуудтай хамтран зохион байгуулах болсноор хамрагдах оюутны тоо нэмэгдэж, японы соёл, зан заншлын тухай хичээлүүдийн тоог нэмсэн.

